

**“АВТО ТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ-ЫН
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ТАЙЛАН**

2026 оны 01 дүгээр
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

НЭГ. ЗОРИЛГО

Энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь “Авто тээврийн үндэсний төв” /“АТҮТ”/ ТӨҮГ-ын 2025 оны үйл ажиллагаа, үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналыг сайжруулж, улмаар түүний үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангахад оршино.

ХОЁР. ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, мөн оны 183 дугаар тогтоолоор баталсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”, 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”, Зам, тээврийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэх журам”-ыг тус тус үндэслэл болгосон.

“АТҮТ” ТӨҮГ-ын 2025 оны үйл ажиллагааг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, сайдын тушаалын хэрэгжилт, нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, байгууллагын ажилтан, албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн хэрэгжилт гэсэн 9 үзүүлэлтээр дүгнэсэн.

ГУРАВ. БОДЛОГЫН ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ

3.1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Хүснэгт 1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны хэрэгжилт

Хэрэгжүүлсэн бодлого	Нийт арга хэмжээ	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)				Дундаж үнэлгээ (хувь)
		“үр дүнтэй” (85 хувиас дээш)	“үр дүн хүлээгдэж байгаа” (60-84 хувь)	“үр дүн хангалтгүй” (30-59 хувь)	“үр дүн гараагүй” (0-29 хувь)	
Бүсчилсэн хөгжил	1	1	-	-	-	100

Эдийн засаг	2	2	-	-	-	100
Нийт	3	3	-	-	-	100.0

Эх сурвалж: www.new.unelgee.gov.mn

3.2. Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт

Хүснэгт 2. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний биелэлт

Хэрэгжүүлсэн бодлого	Нийт арга хэмжээ	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)				Дундаж үнэлгээ (хувь)
		“үр дүнтэй” (85 хувиас дээш)	“үр дүн хүлээгдэж байгаа” (60-84 хувь)	“үр дүн хангалтгүй” (30-59 хувь)	“үр дүн гараагүй” (0-29 хувь)	
Аялал жуулчлалын бүс нутгийн автозамын дэд бүтцийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1	1	-	-	-	100

Эх сурвалж: www.new.unelgee.gov.mn

ДӨРӨВ. ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

4.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

Хүснэгт 3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ, 2025 он

№	Зорилт	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Зорилтын эзлэх жин (%)	Биелэлтийн хувь			Дундаж үнэлгээ (%)
					Бүрэн хангалттай	Хангалттай	Хангалтгүй	
					85%-аас дээш	70%-85%	70% хүртэл	
1	Автотээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлнэ.	1	12	18.4	8	-	4	84.1
2	Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх үйл ажиллагааны хууль, эрх зүйн орчныг сайжруулна.	1	8	12.3	5	1	2	81.2
3	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тээврийн дэд бүтцийг хөгжүүлнэ.	1	5	7.7	2	1	2	66.0
4	Шинэ сэргэлтийн бодлогын эхний үе шатны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд автотээврийн үйлчилгээг үе	1	7	10.8	4	-	3	81.4

	шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлнэ.							
5	Эрх зүйн болон хөгжлийн бодлогын баримт бичиг, тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх олон талт ажлыг зохион байгуулна.	1	12	18.4	12	-	-	98.3
6	Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, нийгмийн асуудал, сургалтын хэрэгцээг нарийвчлан тодорхойлж, ур чадвар олгоход чиглэгдсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулж, сургалтын агуулга, чанар, үр өгөөжийг дээшлүүлнэ	1	6	9.2	5	-	1	92.0
7	Улс хоорондын тээвэрлэлтийн эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр олон улсын гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтийг ханган, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	1	4	6.2	4	-	-	100
8	Тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн хариуцлагыг дээшлүүлж, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулна.	1	9	13.9	7	1	1	92.0
9	Иргэн, аж ахуйн нэгжид тохирлын үнэлгээ хийж, чанарын дэд бүтцийг бэхжүүлнэ.	1	2	3.1	2	-	-	100
Нийт/Дундаж		9	65	100	49	4	12	88.0
Тайлбар: Нийт 65 арга хэмжээний хэрэгжилтийг харгалзан, зорилт тус бүрийн дундаж үнэлгээг арга хэмжээний тоогоор жиллэн тооцоход хэрэгжилтийн дундаж 88.0 хувьтай байна. Энэхүү дүн нь зорилт тус бүрийн бодит хэрэгжилтийг харгалзан гаргасан жиллэсэн үнэлгээ болно.								

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4. Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ, 2025 он

№	Арга хэмжээ, зорилт	Биелэлт	Хувь
1	Улс хоорондын зорчигчийн тогтмол тээврийн үйлчилгээг зохион байгуулах Шалгуур үзүүлэлт: Улс хоорондын зорчигч тээвэрлэлтийн хэмжээ сая.хүн Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: III-IV улирал: 0,5 сая зорчигч тээвэрлэсэн байна.	Улс хоорондын зорчигч тээвэрлэлтээр 2025.01.01-ний өдрөөс 2025.12.15-ны өдрийн байдлаар нийт 15132 тээврийн хэрэгслээр 292,670 зорчигч тээвэрлэсэн бөгөөд суудал ашиглалт дунджаар 43%-тай байна. Зорилтот түвшин 58,5 хувьтай хэрэгжиж байгаа нь улс хоорондын зорчигчийн тогтмол бус тээвэрлэлт эрс нэмэгдэж аялал жуулчлалын зорилгоор хил нэвтрэх иргэд тогтмол бусаар зорчих болсон тул зорчигч урсгал 41,5 хувиар буурсан.	60
2	Импортын ачаа тээврийг бүртгэлжүүлж, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх ажлыг Дг.Замын-Үүд сумаас Улаанбаатар хот хүртэлх чиглэлд эхлүүлж, хилийн бусад боомтуудыг хамруулах Шалгуур үзүүлэлт: Мэдээллийн сан бүрдсэн эсэх	Дг.Замын-Үүд сумаас Улаанбаатар хот руу чиглэсэн импортын ачаа тээврийн мэдээг 2024 оны 12 дугаар сараас эхлэн logistic.transdep.mn программ дээр бүртгэж эхэлсэн. БНХАУ-ын Эрээн-Дг.Замын-үүд боомт чиглэлийн автозамаар орж ирж буй импортын ачаа барааг тогтмол бүртгэж байна. 2025.12.15-ны байдлаар Дг.Замын-Үүд боомтоор импортын бараа 2.3 сая.тн,	50

	<p>Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: III-IV улирал: Хилийн бусад боомтуудаар импортоор орж ирэх ачаа тээврийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлсэн байна.</p>	<p>Сэлэнгэ аймгийн Алтанбулаг боомтоос Улаанбаатар хотын чиглэлд 218,630 тонн импортын бараа тус тус тээвэрлэсэн байна. Хилийн бусад боомтуудаар импортоор орж ирэх ачаа тээврийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх асуудлаар Гаалийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, “Санхүүгийн мэдээллийн технологийн төв” УТҮГ, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ зэрэг байгууллагуудтай удаа дараа уулзалт зохион байгуулж, мэдээлэл хүлээн авах мэдээллийн сан API сервис өгсөн боловч өнөөгийн байдлаар мэдээлэл ирүүлээгүй байна.</p>	
<p>3</p>	<p>Улс, хот хоорондын нийтийн тээврийн автобусны парк шинэчлэлт хийхэд хөнгөлөлттэй зээл олгоход дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллах Шалгуур үзүүлэлт: Зээл олголт эхэлсэн эсэх Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: IV улирал: Зээл олголтыг эхлүүлнэ.</p>	<p>Парк шинэчлэлтэй холбоотой төрөөс хүсэж буй зээлийн хэмжээ, хөнгөлөлтийн нөхцөлийн талаарх судалгааг тээвэрлэлт гүйцэтгэдэг улс, хот хоорондын 39 ААНБ-аас авч эхний байдлаар ЗТЯ-ны АТБЗГ-ын мэргэжилтэн н.Чүнсэрээд цахим хэлбэрээр хүргүүлсэн. Мөн 2025.04.07–11-ний өдрүүдэд БНХАУ-ын “Yutong” ХХК-ийн автобусны үйлдвэртэй газар дээр нь танилцаж, холбогдох удирдлагуудтай хөнгөлөлттэй зээлийн үнээр автобус авах боломжийн судалгааг хамтран хийхээр тохиролцсон бөгөөд хамтарсан судалгааг хийсэн. Энэхүү судалгаагаар аж ахуйн нэгж байгууллагууд парк шинэчлэлтээр хэрэглэгдэж байсан автобус бус цоо шинэ үйлдвэрлэгдсэн автобусыг худалдаж авах боломж, эдийн засгийн үзүүлэлтүүдийг гаргах бөгөөд судалгаанд үндэслэн банк, санхүүгийн байгууллагад хандсан ба холбогдох банк, санхүүгийн байгууллагуудаас ирүүлсэн саналуудыг нэгтгэн 2025.09.12-ны өдөр БНХАУ-ын “Yutong” ХХК, Улс, хот хоорондын ААНБ-уудад автобусны танилцуулга хийж хөнгөлөлттэй зээлийн үнээр автобус олгох боломжийн талаар уулзалт хийсэн. Аж ахуйн нэгж байгууллагууд Хятад автобус өндөр үнэтэй, монголын банк, санхүүгийн байгууллагын хүү өндөр байгаагаас авах боломжгүй байгаагаа илэрхийлсэн.</p>	<p>50</p>
<p>4</p>	<p>БНХАУ-тай шинэчлэн байгуулсан хэлэлцээрийн хүрээнд дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлтийг эхлүүлэх Шалгуур үзүүлэлт: Уулзалт зохион байгуулж, тээвэрлэлт эхэлсэн эсэх Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: III-IV улирал: Хамтарсан хорооны анхны уулзалтыг зохион байгуулж, тээвэрлэлтийг эхлүүлнэ.</p>	<p>Хоёр талын хамтарсан хорооны хурлыг 2025 оны 6-р сард Монгол Улсад зохион байгуулахаар БНХАУ-ын ЗТЯ-тай цахимаар тохиролцож, бэлтгэл ажлыг бүрэн хангасан. ЗТЯ-наас 2025.06.29-ний өдөр зохион байгуулах болсон талаар мэдээллийг тус үйлдвэрийн газарт өгсөн боловч дахин хойшлогдсон, хугацаа тодорхой болохоор чиглэл өгөх талаар мэдэгдсэн. БНХАУ-тай шинэчлэн байгуулсан хэлэлцээрийн хүрээнд G төрлийн зорчих зөвшөөрлийн бичгээр 118 удаагийн тээвэрлэлтийг хийж гүйцэтгэсэн байна. 2025.12.15-ны өдрийн байдлаар Алтанбулаг боомтоор дамжин өнгөрөх чиглэлд орох чиглэлд 290 тээврийн хэрэгсэл, гарах чиглэл 1560 тээврийн хэрэгсэл, Замын-Үүд боомтоор дамжин өнгөрөх чиглэлд орох чиглэлд 1914 тээврийн хэрэгсэл, гарах чиглэл 1864 тээврийн хэрэгслийг тус тус бүртгэлжүүлсэн байна. /Энэхүү уулзалтыг ЗТЯ-наас зохион байгуулах бөгөөд тус үйлдвэрийн газраас бэлтгэл ажлыг хангасан боловч ЗТЯ-ны АТБЗГ-аас 2025.12.15-ны байдлаар</p>	<p>50</p>

		тус уулзалт тодорхойгүй хугацаагаар хойшилсон талаар мэдэгдсэн болно./	
5	<p>Аймаг, нийслэл дэх ТХУ-ийн төвүүдийг магадлан итгэмжлэлд хамруулах</p> <p>Шалгуур үзүүлэлт: Итгэмжлэгдсэн ТХУ-ийн төвийн тоо</p> <p>Хугацаа: I-IV улирал</p> <p>Зорилтот түвшин: III-IV улирал:</p> <p>Аймаг нийслэлийн автотээврийн төвийн 6 техникийн хяналтын үзлэгийн төвийг итгэмжлэлд хамруулна.</p>	<p>2025 онд MNS ISO 17020:2013 стандартын дагуу тохирлын үнэлгээ хийлгэх итгэмжлүүлэх ажлын хүрээнд Архангай, Завхан, Увс, Хэнтий, Сүхбаатар, Дорнод Аймгийн автотээврийн төвүүдэд очиж ажилласан. Энэ ажлын хүрээнд автотээврийн төвүүдийн техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагаа нь MNS ISO 17020 стандартын 111 шаардлагад нийцэж буй эсэхэд тухайн стандартын шалгах хуудсын дагуу үнэлгээ хийж, “Техникийн хяналтын байгууллагын итгэмжлэлийн өргөдлийн маягт”-ын дагуу MNS ISO 17020:2013 стандартын дагуу өөрийгөө үнэлсэн дүгнэлт болон шаардлагатай 15 төрлийн 350-400 орчим хуудас материалыг холбогдох ажилтнуудтай хамтран бүрдүүлж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажилласан.</p> <p>- 2025.02.20-28-ны өдрүүдэд Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан, Архангай аймгийн автотээврийн төвүүд нь Үндэсний итгэмжлэлийн төв рүү итгэмжлүүлэх хүсэлтийг тус бүр илгээсэн.</p> <p>- 2025.02.10--20-ны өдрүүдэд Дархан, Сэлэнгэ аймгийн Автотээврийн төвийн техникийн хяналтын үзлэгийн давтан итгэмжлэлийн өргөдлийн материал бүрдүүлэх ажлыг тухайн төвийн ажилтнуудтай хамтран зохион байгуулан хүсэлт илгээв.</p> <p>- Дээрх аймгийн автотээврийн төвүүдээс илгээсэн итгэмжлүүлэх хүсэлтийн хариуд Үндэсний итгэмжлэлийн төвөөс 2025.03.10-ны өдөр “Нэгдсэн зохион байгуулалтад оруулах тухай” 0/52 тоот бичгээр ирсэн мэдэгдлийн дагуу Автотээврийн үндэсний төвийн нийт техникийн хяналтын үзлэгийн төвүүдийг нэгдсэн байдлаар итгэмжлүүлэх талаар холбогдох удирдлага, ахлах мэргэжилтэнд мэдэгдэж, албан тоотын хариуг 2025.03.31-ны өдрийн 1/367 албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>- Үндэсний итгэмжлэлийн төвд 2025.06.18-ны өдөр 01/653 тоот албан тоотоор Автотээврийн үндэсний төвийн итгэмжлэгдээгүй 24 техникийн хяналтын үзлэгийн төвүүдийн итгэмжлэлийн өргөдөл болон өөрийгөө үнэлэх хуудсыг нэгтгэн хүргүүлсэн.</p> <p>- 2025 онд нийт 8 албан тоотоор итгэмжлүүлэх тухай хүсэлтийг Үндэсний итгэмжлэлийн төвд хүргүүлсэн.</p> <p>- Үндэсний итгэмжлэлийн төвөөс 2025.07.01-ны өдрийн 03/170 тоот албан бичгээр “Нэгдсэн арга зүйгээр хангах тухай” албан бичгийг дахин ирүүлсэн.</p> <p>- “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын техникийн хяналтын үзлэгийн төвүүдийг дангаар итгэмжлүүлэх эсвэл нэгдсэн байдлаар итгэмжлүүлэх тухай “Үндэсний итгэмжлэлийн төв”-тэй нэгдсэн хэлэлцэлд хүрээгүй байна.</p>	30
6	<p>Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүднээс “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх улсын дугаар олгох журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах санал</p>	<p>Зам тээврийн хөгжлийн сайдын/ хуучин нэршилээр/ 2020 оны А/222 дугаар тушаалаар батлагдсан “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх улсын дугаар олгох журам”-д Автотээврийн тухай хууль, Нийслэлийн түгжрэлийг бууруулах гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, Зам тээврийн сайдын</p>	50

	<p>боловсруулан яаманд хүргүүлж, батлуулах Шалгуур үзүүлэлт: Журамд нэмэлт өөрчлөлт орж батлагдсан эсэх Хугацаа: I-III улирал Зорилтот түвшин: III улирал: Сайдын тушаалаар батлагдаж, эрх зүйн хэм хэмжээний акт болон бүртгэгдэн үйл ажиллагаанд мөрдөгдөж эхэлсэн байна.</p>	<p>2025.02.03-ны өдрийн А/24 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах, мөн тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйлчилгээг тодорхой хүртээмжтэй болгох үүднээс тус журамд нэмэлт өөрчлөлт оруулахаар 25 зүйл заалт бүхий санал боловсруулан 2025.05.19-ний өдрийн 01/527 тоот албан бичгээр ЗТЯ-ны АТБЗГ-т хүргүүлсэн. ЗТЯ-ны АТБЗГ-т бүтэц, орон тооны өөрчлөлт орж байгаатай холбогдуулан журмын хэлэлцүүлэг хийгдэхгүй хүлээгдэж байна. Хэлтсийн зүгээс нэмэлт өөрчлөлт оруулах тал дээр бодлогын газрын дарга мэргэжилтэн нарт удаа дараа уламжилж ирсэн. Мөн 2025.12.18-нд ЗТСайдад тулгамдаж байгаа асуудал дээр журмын нэмэлт өөрчлөлт орох ажил удааширалттай байгаа талаар тусгасан.</p>	
<p>7</p>	<p>Орон нутагт зорчигч тээврийн автобуудал байгуулах Шалгуур үзүүлэлт: Автобуудлын барилгын ажлын гүйцэтгэл, хувь Хугацаа: I-IV улирал Зорилтот түвшин: III-IV улирал: 1. Говь-Алтай аймгийн автобуудлын барилгын ажлыг 70%-д хүргэнэ. 2. Ховд аймгийн автобуудлын барилгыг ашиглалтад оруулж, үйлчилгээг эхлүүлнэ. 3. Замын-Үүдийн автобуудлын барилга угсралтын ажлыг 70 хувьд хүргэнэ.</p>	<p>Замын-Үүд: Дорноговь аймгийн Замын-Үүд суманд барих, ашиглах, шилжүүлэх нөхцөлтэй концессын гэрээгээр баригдаж байгаад ашиглалтад ороогүй Зорчигч тээврийн автобуудлын барилгын ажлыг хүлээж авах ажлын хэсгийг ЗТХС-ын тушаалаар 2023.05.01-ний өдөр байгуулсан. 2023.04.06-07-ны өдрүүдэд “АТҮТ” ТӨҮГ, “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын холбогдох албан хаагчид болон АТБХЗГ-ын ТЗБХ-ийн даргаар ахлуулсан ажлын хэсэг Дорноговь аймгийн Замын-Үүд суманд ажиллаж, барилгын дуусаагүй ажлын нөхцөл байдалтай танилцаж, зураг төсөв хүлээлцэх, барилгын одоогийн суурийн ажилд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулахаар дээж авч, холбогдох газарт хүргүүлсэн. Тус үйлдвэрийн газраас ЗТХЯ-тай хамтарсан ажлын хэсэг 2024.03.22-24-ний өдрүүдэд Замын-үүд суманд албан томилолтоор ажиллаж, барилгын ажлын одоогийн байгаа нөхцөл байдал болон цаашид хэрэгжүүлэх ажлын талаар олон нийтэд мэдээлэл өгсөн. Мөн Дорноговь аймгийн Замын-Үүд суманд баригдаж байгаад зогссон зорчигч тээврийн автобуудлын барилга байгууламжийн холбогдох зураг, төсөв бусад баримт материалыг 2024.09.16-ны өдөр ЗТЯ-нд акт үйлдэн хүлээлгэж өгсөн болно. Тус автобуудлын шинэчлэгдсэн төсвийг барилгын хөгжлийн төвийн магадлалын ерөнхий дүгнэлтэд оруулсан. Магадлалын ерөнхий дүгнэлт бэлэн болохоор ЗТЯ-нд хүлээлгэж өгнө. Говь-Алтай: Автобуудал, техникийн хяналтын үзлэгийн төвийн барилгыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024-2026 онд нийт 3,2 тэрбум төгрөгийн хөрөнгөөр барьж байгуулахаар тусгагдсан. Төрийн худалдан авах ажиллагааны газраас ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа зохион байгуулсан бөгөөд “Мөрөн-Алтай” ХХК шалгарч, ЗТХЯ-тай гэрээ байгуулсан. Зураг төсөвт яаралтай өөрчлөлт оруулан зургийн ажлыг бүрэн дуусгасан. Барилга эхлүүлэх зөвшөөрлийг аймгийн Хот байгуулалт, газрын харилцааны газраас авч, барилгын ажил эхэлсэн бөгөөд 50 хувийн гүйцэтгэлтэй байна. 2025 оны 4-р улирлын байдлаар</p>	<p>50</p>

		<p>барилгын ажил улирлын шалтгаанаас болж зогссон байна.</p> <p>Говьсүмбэр: Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Говьсүмбэр аймгийн автобуудлын барилгыг барих талаар үйлдвэрийн газраас ТӨБЗГ-т хүсэлт гаргаж, ЗТХЯ-наас дэмжлэг авч, шийдвэрлүүлэхээр хүсэлт хүргүүлсэн. Говьсүмбэр аймгийн автобуудал барилгын ажил эхлээгүй газрын асуудал яригдаж байна 2023.11.08-ны өдөр “Өв хангамж групп” ХХК-тай уулзалт хийж, тус компаниас ТӨБЗГ-т албан бичиг хүргүүлсэн. “Өв хангамж групп” ХХК-аас тус үйлдвэрийн газарт холбогдох тооцоо судалгааг гаргаж, ирүүлээгүй байна.</p> <p>Ховд: ЗТХЯ, ТӨБЗГ, “Автотээврийн үндэсний төв”, “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын холбогдох албан тушаалтнуудаас бүрдсэн ажлын хэсгийг тус үйлдвэрийн газрын захирлын 2024.03.22-ны өдрийн А/75 дугаар тушаалаар байгуулсан.</p> <p>Ховд аймгийн зорчигч тээврийн барилгын ажлын гүйцэтгэл 95 хувьтай хэрэжиж байгаа бөгөөд 2026 оны 01 дүгээр сард Улсын комисс ажиллаж, хүлээн авна.</p>	
8	<p>Дорноговь аймгийн Замын-Үүд суманд техникийн хяналтын үзлэгийн төвийн барилга шинээр барих</p> <p>Шалгуур үзүүлэлт: Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь</p> <p>Хугацаа: I-IV улирал</p> <p>Зорилтот түвшин: IV улирал: Барилгын ажлыг 100% гүйцэтгүүлж, хүлээн авсан байна.</p>	<p>Дорноговь аймгийн Замын-Үүд сумаас барилгын техникийн нөхцөл, архитектур төлөвлөлтийн даалгавар хоцорч ирсэн тул зургийн ажил удааширсан. 2025 оны 3-р улирлын байдлаар тус техникийн хяналтын үзлэгийн төвийн барилгын зураг, төслийн ажил хийгдэж дууссан. Газрын үнэлгээ гарсан.</p> <p>Барилгын хөгжлийн төвөөс магадлалын ерөнхий дүгнэлт гарсны дараа сонгон шалгаруултыг зарлахаар бэлтгэл ажлыг хангаж байна.</p>	10
9	<p>Autobox гар утасны аппликейшнийг тогтмол шинэчлэн хөгжүүлэлт хийх</p> <p>Шалгуур үзүүлэлт: Шинээр нэвтрүүлсэн цахим үйлчилгээний тоо</p> <p>Хугацаа: I-IV улирал</p> <p>Зорилтот түвшин: Autobox гар утасны нэмэлт хөгжүүлэлтийг тогтмол хийж, шинэ 2-оос доошгүй цахим үйлчилгээг нэвтрүүлсэн байна.</p>	<p>Autobox гар утасны аппликейшнд 2 удаагийн шинэчлэлт хөгжүүлэлт хийж, хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.</p> <p>Тайлант хугацаанд тус аппликейшнд Хот хоорондын зорчигч тээвэрлэлт гүйцэтгэж буй жолоочийн ажил амралтын дэглэмийг хянах цахим үйлчилгээг нэвтрүүлсэн.</p>	50
10	<p>Байгууллагын дотоод ERP системд тогтмол хөгжүүлэлт хийж, боловсронгуй болгох</p> <p>Шалгуур үзүүлэлт: Системийн хөгжүүлэлтийн ажлын явц</p> <p>Хугацаа: -IV улирал</p> <p>Зорилтот түвшин: IV улирал: ERP системээр эрхийн зохицуулалтаар мэдээлэл харах боломжийг бүрдүүлсэн байна.</p>	<p>Байгууллагын дотоод ERP системд тогтмол хөгжүүлэлт хийж өгөгдсөн үүрэг даалгавар, ирсэн өргөдөл гомдлыг цахимаар бүртгэх, биелэлтийг цахимаар авах боломжийг бүрдүүлсэн. Албан бичиг хуваарилалт, засвар үйлчилгээний захиалаа, тушаал шийдвэр, мэдээ мэдээллийн булан зэрэг өдөр тутам ERP системийг тогтмол ашиглаж байгаа.</p> <p>Системийн хөгжүүлэгч ажлаас гарсан учир нэмэлтээр хөгжүүлэлт хийгдээгүй бөгөөд ERP систем дотор байгаа мэргэшсэн жолоочийн шалгалт авах үнэмлэх хэвлэх систем гацах, үйлчилгээний төлбөр төлж болохгүй байх, онлайн тасалбар захиалааг баталгаажихгүй удах зэрэг асуудлууд гарсныг засварлаж одоо хэвийн ажиллаж байна.</p>	50

		Мөн хэрэглэгчийн эрхүүдийг бүгдийг эхнээс нь тохируулсан бөгөөд адил албан тушаалтай боловч давуу эрхтэй хэрэглэгчид байсан зэрэг асуудал бүрэн цэгцэрсэн.	
11	<p>Автомтээрийн салбарын Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2023-2025 оны хамт /тариф/-ын хэлэлцээрийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх Шалгуур үзүүлэлт: 3 талт хамтын хэлэлцээр дүгнэгдсэн эсэх</p> <p>Хугацаа: I-IV улирал</p> <p>Зорилтот түвшин: II-IV улирал:</p> <p>Төлөвлөгөөний хэрэгжилтийг улирал тутам гаргаж яаманд хүргүүлж, жилийн эцэст гурван талт хамтын хэлэлцээрийг дүгнүүлсэн байна.</p>	<p>Үйлдвэрийн газрын дэргэдэх Үйлдвэрчний эвлэлийн хороо нь 2025 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, Автомтээрийн салбарын Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2023-2025 оны хамт /тариф/-ын хэлэлцээрээс холбогдох заалтуудыг тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үйлдвэрчний эвлэлийн хороо нь 2025 онд таван зорилтын хүрээнд 15 ажил хийхээр тусган төлөвлөгөөг 2025.01.15-ны өдөр батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.</p> <p>Төлөвлөгөөний хэрэгжилтийг 2025 оны 3-р улирлын байдлаар гаргаж, ЗТЯ-нд 2025.09.23-ны өдрийн 05 тоот албан бичгээр хүргүүлж, тайлагнасан.</p> <p>Мөн Автомтээрийн салбарын хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хамтын хэлэлцээр болон Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбогдуулан ажил олгогч болон ажилтнуудын төлөөлөл хоорондын хамтын гэрээний шинэчилсэн найруулгын төслийг 2025.12.11-ний өдрийн 06 тоот албан бичгээр ажил олгогчид хүргүүлсэн.</p>	50
12	<p>“Оюутан тээвэр” хяналтын нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах Шалгуур үзүүлэлт: Хяналт шалгалт хийгдсэн эсэх, илэрсэн зөрчил буурсан хувь</p> <p>Хугацаа: II-IV</p> <p>Зорилтот түвшин: IV улирал:</p> <p>Зөрчил 80 хүртэл хувиар буурсан байна.</p>	<p>Оюутан тээвэр” хяналтын нэгдсэн арга хэмжээ нь Хавар оюутан орон нутаг руу буцах чиглэлд, Намар оюутан Улаанбаатар хот руу ирэх чиглэлд зорчигч урсгал эрс нэмэгддэг тул тус хяналт шалгалтын арга хэмжээг жил болгон зохион байгуулдаг.</p> <p>2025 оны хавар хийгдэх оюутан тээврийн хяналт шалгалтын арга хэмжээ зохион байгуулах хугацаанд Зам, тээврийн сайдын 2025.01.09-ний өдрийн А/03 дугаар “Удирдамж батлах тухай”, Зам, тээврийн яамны Салбарын хяналтын газрын даргын 2025.04.10-ны өдрийн 04/24 дугаар “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд хилийн боомт тус бүрээр улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд нийт автоматтээрийн хяналтын улсын байцаагчид нь 2025.04.21-2025.05.23-ны өдрүүдэд хяналт шалгалтын ажил хийсэн тул тус шалгалтыг төлөвлөж байсны дагуу шугам замын хяналт, шалгалтаар гарч ажиллаагүй.</p> <p>Оюутан тээврийн ажлын хүрээнд хийгдэх намрын хяналтын нэгдсэн арга хэмжээг 2025.08.26-ний өдрөөс 2025.09.10-ны хооронд зохион байгуулсан.</p> <p>Шалгалтад нийт 1056 тээврийн хэрэгсэл хамрагдсан. Үүнээс хот хоорондын 68 зөрчилд 3.450.000 төгрөгийн торгууль оногдуулж 40 зөрчлийг газар дээр нь арилгуулсан. Тээвэрлэлтийн гэрээгүй /хууль бус/ 191 зөрчилд 19.100.000 төгрөг, ачаа тээврийн 1 зөрчилд 150000 төгрөг, нийт 22.550.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ оногдуулсан. Өнгөрсөн үеийн мөн үетэй харьцуулахад зөрчил 77 хувиар буурсан үзүүлэлттэй байна.</p>	50

4.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Хүснэгт 5. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээний дүн, 2025 он

Эрх зүйн актын төрөл	Заалтын тоо	Үнэлгээ /заалтын тоо					Үнэлгээний дундаж (хувь)
		Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хэрэгжих боломжгүй	
		100%	50%	0%	ХБ		
УИХ-ын тогтоол	1	1	-	-	-	-	100
ҮАБЗ-ийн зөвлөмж	1	1	-	-	-	-	100
Засгийн газрын тогтоол	10	8	1	-	-	1	94.4
Ерөнхий сайдын захирамж	1	1	-	-	-	-	100
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	10	10	-	-	-	-	100
ЗГ-ын албан даалгавар	1	-	1	-	-	-	50
Нийт	24	21	2	-	-	1	91

Эх сурвалж: www.new.unelgee.gov.mn

Хэрэгжих боломжгүй гэж үнэлэгдсэн тогтоолын заалтыг дурдвал:

Хүснэгт 6. Хэрэгжих боломжгүй арга хэмжээ, 2025 он

д/д	Засгийн газрын тогтоол	Холбогдох заалт	Үнэлгээ
1	2024_191_01. Жуулчдын урсгалыг нэмэгдүүлж, дөрвөн улирлын турш жуулчин хүлээн авах зорилтын хүрээнд хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	3.2. Оросын Холбооны Улсаас ирэх жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх хүрээнд Улаанбаатар-Улаан-Үдийн чиглэлийн зорчигч тээврийн үнийг бууруулах боломжийг судалж, зохих арга хэмжээ авахыг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайханд, "Шинэ жил-Монголд" арга хэмжээг олон улсын түвшинд зохион байгуулж, холбогдох зардлыг шийдвэрлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатарт.	Хэрэгжүүлэх зардал, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй

Эх сурвалж: www.new.unelgee.gov.mn

4.3. Сайдын тушаалаар өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилт

Хүснэгт 6. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт, 2025 он

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хэрэгжих боломжгүй	
18	17		1	-	-	94.4

Хэрэгжээгүй арга хэмжээг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 7. Хэрэгжээгүй арга хэмжээ, 2025 он

№	Тушаал	Үүрэг даалгавар	Хэрэгжилт тайлагнасан байдал

1	Ажлын хэсэг байгуулах тухай 2025.08.20 А/212	Монгол Улсыг Бүгд Найрамдах Казахстан Улстай холбох автотээврийн дөт коридор байгуулах, маршрут тогтоох, шаардлагатай тооцоо судалгааг хийж холбогдох шийдвэр гаргуулах үүрэг бүхий үйл ажиллагаанд шаардагдах зардлыг санхүүжүүлэх арга хэмжээ авахыг “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын захирал Б.Гүрсоронзон, “Монголын Автотээвэрчдийн нэгдсэн холбоо” ТББ-ын гүйцэтгэх захирал Д.Наранпүрэв	Ажлын хэсгээс чиглэл ирүүлээгүй байна.
---	--	---	--

ТАВ. ЧАДАМЖИЙН ҮНЭЛГЭЭ

5.1. Нээлттэй мэдээллийн ил тод байдал

Хүснэгт 8. Мэдээллийн ил тод байдлын үнэлгээ, 2025 он

д/д	Үзүүлэлтийн бүлэг	Үнэлгээ (хувь)
1	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	91.0
2	Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	83.0
3	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	83.0
4	Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх ил тод, нээлттэй байдал	81.0
5	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	88.0
Дүн		86.0

5.2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Хүснэгт 9. Шилэн дансны хөтлөлтийн ерөнхий мэдээлэл, 2025 он

д/д	Мэдээллийн төрөл	Байршуулсан мэдээллийн тоо		Биелэлт (хувь)
		Хугацаанд нь	Хугацаа хоцроосон	
1	Төсөв/гүйцэтгэл	52	1	98
2	Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	38	0	100
3	Бусад	85	0	100
Нийт		175	1	99.3

Эх сурвалж: Сангийн яам, shilendans.gov.mn

Хугацаа хоцроон байршуулсан мэдээлэл:

Хүснэгт 10. Хугацаа хоцроосон мэдээлэл, 2025 он

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах хугацаа	Мэдээлэл оруулсан огноо
1	Төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт	2025.03.08	2025.03.10

5.3. Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Хүснэгт 11. Хяналт шалгалт, аудитын зөвлөмжийн хэрэгжилт

д/д	Хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээ хийсэн байгууллага	Акт, албан шаардлага, зөвлөмжийн тоо			Хувь
		Нийт	Үүнээс		
			Хэрэгжсэн	Хугацаа болоогүй	
1	Үндэсний аудитын газар	22	14	-	64
2	Зам, тээврийн яам	4	4	-	100

Нийт	26	18	-	69.2
------	----	----	---	------

5.4. Байгууллагын ажилтан, алба хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн хэрэгжилт

Хүснэгт 12. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, 2025 он

Зорилт	Үйл ажиллагаа	Үнэлгээ (%)
Цалин хөлс, тэтгэмж, тусламж, нөхөх төлбөр, олговор, шагнал урамшууллыг дагуу олгох	1.Албан тушаалын үндсэн цалин болон нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал, хоол, унааны мөнгийг жил бүрийн төсөвт тусган олгох.	100
	2.Цалин хөлсийг нэмэх, бууруулах, шагнаж урамшуулах, хариуцлага тооцох асуудлыг шийдвэрлэх.	90
	3.Ажлын зайлшгүй шаардлагаар өөр албан тушаал түр хавсран гүйцэтгэсэн тохиолдолд нэмэгдэл хөлс олгох.	100
	4.Ажилтны нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын хураамжийн нөхөх төлбөрийг төлөх	100
	5.Албан томилолтын зардал олгох.	100
Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, аятай нөхцөлөөр хангах	1.Шаардлагатай бичгийн хэрэгсэл болон тоног төхөөрөмж, багаж, техник хэрэгсэл, хувцсаар хангах.	100
	2.Албан ажлын өрөөнүүдийг агааржуулах тоног төхөөрөмж суурилуулах, цэцэгжүүлэх арга хэмжээг авах.	100
	3.Чийрэгжүүлэх, спортоор хичээллэх нөхцөл боломжоор хангах	100
	4.Сургалт хийх, сургалтын техник, тоног төхөөрөмжөөр хангах	95
Орон сууцны нөхцөлөө сайжруулахад дэмжлэг үзүүлэх	1.Орон сууцны зээл, хөтөлбөрт хамруулах, орон сууцны хүрэлцээ, хангамж нөхцөлийг сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх.	100
	2.Ажилтныг орон сууцны зээл авахад нь албан тодорхойлолт гаргаж өгөх.	100
Эрүүл мэндийг хамгаалах ажлын хүртээмж, чанарыг дээшлүүлэх	1.Ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй тохиолдолд 1.5 сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох	100
	2.Эрүүл мэндийн болон эрүүл аж төрөх зан заншлын мэдлэг олгох сургалтыг эрүүл мэндийн байгууллагатай хамтран зохион байгуулах	100
	3.Ажилтнуудыг жил тутам эрүүл мэндийн сорилд хамруулж, эмнэлгийн үйлчилгээний төлбөрийг төвөөс төлөх	100
	4.Эмчилгээ зайлшгүй шаардлагатай ажилтанд гадаад оронд эмчлүүлэхэд 1 сарын цалинтай тэнцэх мөнгөн тэтгэлэг олгох	100
Амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, ажиллах идэвх санаачилгыг нэмэгдүүлэх	1.Ажлын туршлагыг түгээн дэлгэрүүлэх, гадаад орны адил чиг үүргийн байгууллагын туршлага судлуулах зэргээр дэмжих	90
	2.Ажил мэргэжлийн аварга шалгаруулах уралдаан, урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулах	100
	3.Тус газраас тэтгэвэрт гарсан хүмүүст цагаан сар, ахмадын өдрөөр хүндэтгэл үзүүлэн тусламж, тэтгэмж олгох.	100
	4.Ажилтны 0-16 насны хүүхдэд “Хүүхдийн баяр” болон “Шинэ жил”-ийн баярыг тохиолдуулан бэлэг гардуулах	100
Дундаж үнэлгээ		98.5

ЗУРГАА. ДҮГНЭЛТ

“АТҮТ” ТӨҮГ-ын 2025 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр тус газрын ерөнхий үнэлгээ 92 хувьтай байна. Энэ нь өмнөх оны үнэлгээний дунджаас 7.8 нэгж хувиар өсчээ

Хүснэгт 14. Ерөнхий үнэлгээ, 2025 он

Үзүүлэлт		Хэрэгжилт (хувь)
1	2	3
Бодлогын үр дүн	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	100.0
	Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт	100.0
Чиг үүргийн үзүүлэлтийн дүн	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	88.0
	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	91.0
	Сайдын тушаалын хэрэгжилт	94.4
Чадамжийн үнэлгээ	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ	86.0
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	99.3
	Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт	69.2
	Байгууллагын ажилтан, албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн хэрэгжилт	98.5
Ерөнхий дүн (жинлэсэн дундаж)		92.0

Үнэлгээний үзүүлэлт бүрийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 7.7, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 3, сайдын тушаалын хэрэгжилт 8.2, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 4.9, нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ 2.9 нэгж хувиар тус тус өссөн эерэг үзүүлэлттэй байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээний хэрэгжилт “хангалтгүй” гэж дүгнэгдсэн нь төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн төлөвлөөгүй, ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэр шийдэгдээгүй, хэрэгжүүлэгч байгууллагын удирдлага, зохион байгуулалт хангалтгүй, тухайн арга хэмжээний шалгуур үзүүлэлт нь зорилт, арга хэмжээтэй уялдаагүй, бусад байгууллагаас зөвшөөрөл олгох, хамтран хэрэгжүүлэх үйл явц удаашралтай зэрэг шалтгаантай холбоотой гэж дүгнэлээ.

Нээлттэй мэдээллийн ил тод байдалд хийсэн хяналт-шинжилгээгээр тус газрын мэдээллийн хүртээмжтэй байдал дутмаг, мэдээллийн самбарт байршуулсан байдал болон бусад мэдээллийн хэрэгслээр нийтэд хүртээмжтэй байдлаар хүргэх үйл ажиллагаа хангалтгүй, зарим мэдээлэл шинэчлэгдээгүй удсан, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, цахим шуудангийн хаяг байхгүй, тайланд нотлох баримтыг дутуу хавсаргасан зэрэг нөхцөл байдал тогтоогдлоо.

Тус газар нь 2025 оны эрсдэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа “Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлого”, “Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх заавар”, “Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг үнэлэх аргачлал” зэрэг баримт бичгүүдийг удирдлага болгоогүй, эрсдэлийг илрүүлэх, шинжлэх, үнэлэх, хариу арга хэмжээ авах, эргэн хянах үйл явц огт тусгагдаагүй, агуулгын хувьд ерөнхий шинжтэй ажил, арга хэмжээг төлөвлөжээ. Иймд аргачлалын дагуу хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх боломжгүй тул үнэлгээний шалгуур үзүүлэлт болгож байгууллагын үйл ажиллагааны ерөнхий дүнд оруулаагүй болно.

“АТҮТ” ТӨҮГ-ын захирлын 2019 оны А/386 дугаар тушаалаар батлагдсан “Ажилтны нийгмийн баталгааг хангах хөтөлбөр” нь 2020-2025 онд хэрэгжиж, төлөвлөсөн хугацаандаа дууссан байна. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлснээр ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийг хамгаалах ажлын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, ажиллах орчны аятай таатай нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр тодорхой ахиц, үр дүн гарсан байна гэж дүгнэлээ.

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

“Авто тээврийн үндэсний төв” /”АТҮТ”/ ТӨҮГ-ын 2025 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн бодлого, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулахтай холбоотой дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Зөвлөмж болгож байна. Үүнд:

7.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай ажил, арга хэмжээг эрэмблэн тусгаж хэрэгжүүлэх;

7.2. Цаашид бодлогын баримт бичиг, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад байнгын хяналт тавьж, хэрэгжилт удаашралтай, хангалтгүй арга хэмжээний биелэлтийг эрчимжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч, биелэлтийг бүрэн хангуулах;

7.3. Бодлогын баримт бичиг, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу зорилтот түвшинд хүрсэн эсэхийг нотлох баримтад үндэслэн үнэн зөв тайлагнаж ирүүлж байх;

7.4. Шилэн дансны тухай хуулийг чанд мөрдөж, тогтоосон хугацаанд нь холбогдох мэдээллийг цахим хуудсанд иж бүрэн, үнэн зөв байршуулж, мэдээллийн ил тод байдлыг хангах;

7.5. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үзүүлэлтийг тайлагнахдаа холбогдох хууль тогтоомжид заасан шалгуур үзүүлэлтийн дагуу нотлох баримтыг хавсаргах, вэб сайт дээрх нээлттэй мэдээллийг тогтмол шинэчилж, дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж, холбоо барих албан тушаалтны мэдээллийг бүрэн байршуулж байх;

7.6. “Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлого”, “Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх заавар”, “Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг үнэлэх аргачлал” зэрэг баримт бичгүүдэд үндэслэн байгууллагын эрсдэлийн төлөвлөгөө боловсруулж, заалт бүрийг эзэнжүүлэн хэрэгжилтийг хангах;

7.7. Байгаль орчныг хамгаалах нийтлэг чиг үүргийн хүрээнд ажилтнуудад экологийн боловсрол олгох сургалт зохион байгуулах, цахилгаан автомашины хэрэглээг нэмэгдүүлэх, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөө багатай түлш ашиглах, орон нутагт цахилгаан автомашин цэнэглэх станцын тоог нэмэгдүүлэх, автомашинаас үүдэлтэй аюултай хог хаягдлыг дахин боловсруулах, олон улс, улсын чанартай автозамын дагуу үйлчилгээний цогцолборуудыг байгальд ээлтэй байдлаар байгуулж, хүрээлэн буй орчны бохирдлыг багасгах зэрэг ажлыг төрийн бусад байгууллага, хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулах;

7.8. Ажилтан, албан хаагчийн сургалт, нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийг дахин боловсруулахдаа бодит хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох судалгаа хийсний үндсэн дээр улс орны эдийн засгийн нөхцөл байдал, байгууллагын батлагдсан төсөв, өөрийн дотоод нөөц бололцоотой уялдуулан бодитой, хэрэгжихүйц байдлаар төлөвлөх;

“СХШҮДАГ”

**“АТҮТ” ТӨҮГ-ЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН**

/Хүснэгтээр/

Үзүүлэлт		Хэрэгжилт (хувь)
1	2	3
Бодлогын үр дүн	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	100.0
	Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт	100.0
Чиг үүргийн үзүүлэлтийн дүн	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	88.0
	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	91.0
	Сайдын тушаалын хэрэгжилт	94.4
	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээ	86.0
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	99.3
	Эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээний хүрээнд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт	69.2

Чадамжийн үнэлгээ	Байгууллагын ажилтан, албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн хэрэгжилт	98.5
Ерөнхий дүн (жинлэсэн дундаж)		92.0

/Графикаар/

